

2017 ОНЫ 08 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДРИЙН
НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

№	Товч агуулга	Хэрэгжилт
1	<p>2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах газрын 2017 оны 186 дугаар тогтоол “Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” Засгийн газрын 2017 оны 187 дугаар тогтоол “Төв суурины газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангах тухай” Сайдын болон нийслэлийн Засаг даргын 2017 оны 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн явцын дүнг нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах. /Захирагчийн ажлын алба, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Геодези, усны барилга, байгууламжийн газар, Ус сувгийн удирдах газар, Хэсэгчилсэн инженерийн байгууламжийн ашиглалт, зохиоцуулалтын газар, УБ Дулааны шугам сүлжээ ХК, УБ Цахилгаан түгээх сүлжээ ХК, Хот тохижилтын газар, Улаанбаатар зам засвар арчлалтын газар, Дүүргийн ЗДТГазрууд/</p>	<p>Засгийн газраас 2017 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээ”-ний тухай 186 дугаар тогтоолыг баталсан бөгөөд тогтоолд улсын хэмжээнд өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах талаар тодорхой ажлуудыг авч хэрэгжүүлэх талаар тусгасан байна.</p> <p>Уг тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар Нийслэлийн засаг даргын 04 албан даалгаврыг гаргуулан мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн 6 дүүрэгт хүргүүлэн, төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллах талаар ажлын чиглэл өгсөн.</p> <p>Нийслэлийн мал аж ахуйн салбарын 2017 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах хүрээнд дүүргүүдээс санал авч, нэгтгэн төлөвлөгөө гарган, захирамжийн төслийг боловсруулан ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 186 дугаар тогтоолд улс, аймаг, нийслэлийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх талаар даалгасан бөгөөд Нийслэлийн хэмжээнд 438 мянган малыг хонин толгойд шилжүүлэн тооцвол 500 тн өвс, 300 тн тэжээл аюулгүйн нөөцийг бэлтгэх үүрэг өгсөн.</p> <p>Дүүргүүдийн хэмжээнд аюулгүйн нөөц бүрдүүлэхэд санхүүгийн эх үүсвэр муу, өвс, тэжээлийг хадгалах, агуулах савгүй, хадлан бэлтгэх талбай жил бүр багасаж, отрын бэлчээр, нутаггүй байгаа бөгөөд өөр аймаг, сумдын нутагт хадлан өвс бэлтгэх, өвөлжих боломж тааруу зэрэг нийтлэг бэрхшээлтэй асуудлууд байна.</p> <p>Нийслэлийн хэмжээнд 8 дүүргийн 54 хорооны 4100 гаруй өрхийн 438 мянган толгой мал өвөлжих мэдээтэй байна.</p> <p>Одоогийн байдлаар өндөглөгч тахианы тэжээл 1 тн-1.150.0 мянга, саалийн үнээний тэжээл 660.0 мянга, адууны тэжээл 750.0 мянга, бүх малд зориулсан хорголжин тэжээл 600.0 мянга, гахайны тэжээл 660.0-750.0 мянган төгрөгийн үнэ ханштайгаар үйлдвэрээс гарч байна.</p> <p>Өөр аймгийн нутагт отроор өвөлжих магадлалтай 220 гаруй өрхийн 48.798 мянган мал, өөр аймгийн бусад сумын нутагт 20 гаруй өрхийн 1638.0 мянга орчим мал, тусгай хэрэгцээний отрын бүс нутагт 50 гаруй өрхийн 600.0 мянга гаруй мал буюу, нийт 300 гаруй өрхийн 51000.0 мянга орчим мал отор нүүдэл хийх урьдчилсан мэдээтэй байна.</p>

		<p>Малчдыг өвөлжилтийн бэлтгэл хангуулах зорилгоор Төв, Сэлэнгэ, Дорнод аймгийн Засаг дарга нарт Нийслэлийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 31 ны өдрийн 02-02/27,25 тоот хадлангийн газар хүссэн албан бичиг хүргүүлж ажиллалаа.</p> <p>Засгийн газрын 2017 оны 186 дугаар тогтоол, ХХААХҮЯамны сайдын 02 албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын 04 албан даалгаварыг хэрэгжилтийг хангахын тулд Нийслэлийн 2017-2018 оны мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах,цаг агаарын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах зорилгоор нийслэлд өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд 357.4 сая төгрөг шаардлагатай байгаа учраас энэ ажилд зарцуулах санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр уг төсөлийг танилцуулж байна.</p>
2	<p>Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг үргэлжлүүлж, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/592 дугаар захирамжаар дагуу хотын хориглосон бүс, нутагт байгаа малыг зөвшөөрсөн бүс нутаг руу шилжүүлэх ажлыг 2017 оны 11 дүгээр сарын 01-ны дотор зохион байгуулах. /Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, нийслэлийн Мал эмнэлгийн газар,Нийслэлийн Онцгой байдлын алба, Дүүргийн ЗДТГазрууд/</p>	